эрх зүйн орчинд шинжилгээ хийж, салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулахын зэрэгцээ Монгол Улсын батлан хамгаалах болон гамшигтай тэмцэх тогтолцоонд тулгуурлан Үндэсний сөрөн тэсвэрлэх стратегийг боловсруулах цаг нэгэнт ирсэн байна. Эх оронч Монгол хүн бол Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх үндсэн субъект болохын хувьд Эх оронч Монгол хүнийг төлөвшүүлэх, хүүхэд залуучуудыг эх оронч үзэлтэй Монгол хүн болгон хүмүүжүүлэх, бүх шатны боловсролын байгууллагыг энэ ажилд чиглүүлэх нь үндэсний хэмжээний ач холбогдолтой ажил болж байна.

Тус өгүүлэлд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын үндсэн ойлголт, түүний үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар авч үзсэний зэрэгцээ дэлхийн улс орнуудын үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги болон тогтолцоонд судалгаа хийж, зарим техник, эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэй улсууд болох Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Европын Холбооны Улс, Япон зэрэг улсуудын жишээг тусгасан. Мөн манай улсын хоёр хөрш улс болох Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улсуудын жишээг авч үзсэн.

Эх оронч үзлийн талаар судлан тухайн үзэл санаа улс орны үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхад хэрхэн нөлөөлдөг талаар авч үзсэн. Эх оронч үзэл, эх оронч иргэд нь үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхад хэрхэн хувь нэмэр оруулж болох талаар салбар бүрд тодорхой жишээ авч судалгаанд багтаасан. Мөн эх оронч Монгол хүн гэж хэн байх вэ гэдгийг тодорхойлон Үндэсний батлан хамгаалахын их сургууль эх оронч үзэлтэй иргэн бэлтгэж гаргах боломжийн талаар судалсан. Мөн тус их сургуулийн оны зорилт үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, эх оронч иргэн бэлтгэх асуудалд хэрхэн туссан талаар авч үзсэн болно.

Түлхүүр үг: Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхийн үндсэн бүрэлдэхүүн, үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги, эх оронч үзэл, эх оронч хүн

I. УДИРТГАЛ

Олон улсын геополитикийн нөхцөл байдал ээдрээтэй болж байгаа өнөө үед гаднын улс, үндэстнээс ирж болох аюул, зөөлөн хүчний бодлогыг тэсвэрлэх, даван туулах, хариу арга хэмжээ авах асуудал улс, үндэстэн бүрийн амин чухал асуудал болохын зэрэгцээ учирч болох байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, төрөл бүрийн гоц халдварт өвчний дэгдэлт, хүний хүчин зүйлээс үүдэлтэй болон үүдэлгүй төрөл бүрийн осол, сүйрэл, төрөл бүрийн террорист болон кибер халдлагуудад бэлтгэлтэй байж, түүнийг тэсвэрлэх, даван туулах, хурдан хугацаанд сэргээх, хариу арга хэмжээ авах асуудал нэн өндөр ач холбогдолтой болж байна.

II. ҮНДЭСНИЙ СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХ

Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гэдэг нь байгалийн гамшиг, эдийн засгийн хямрал, кибер халдлага, үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн аюулууд гэх мэт сөрөг нөхцөл байдлыг үл харгалзан тухайн үндэстний тэсвэрлэх, дасан зохицох,

сэргэх, хөгжих чадварыг хэлнэ. Энэ нь болзошгүй эрсдэлд бэлтгэх, тэдгээрийн нөлөөллийг багасгах, илүү хүчтэй хариу арга хэмжээ авах явдал юм¹⁴.

Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын үндсэн бүрэлдэхүүнд дараах чадавхууд багтана.

1. Эдийн засгийн сөрөн тэсвэрлэх чадавх: Эдийн засгийн хямралын (сүйрэл, тасалдал) дараа эдийн засгийг хурдан сэргээх, үргэлжлүүлэн хэвийн ажиллагаанд оруулах боломж.

2. Дэд бүтцийн сөрөн тэсвэрлэх чадавх: Зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүчний системүүд гэх мэт зайлшгүй шаардлагатай бүтцүүдийн найдвартай ажиллагааг хангах.

3. Нийгмийн сөрөн тэсвэрлэх чадавх: Хямралын үед олон нийтийн эв нэгдлийг хангах, сэтгэцийн эрүүл мэндэд анхаарах нийгмийн сүлжээтэй байх.

4. Улс төрийн сөрөн тэсвэрлэх чадавх: Засгийн газрын тасралтгүй үйл ажиллагаа болон үр дүнтэй шийдвэр гаргах үйл ажиллагааг хангах

5. Аюулгүй байдал, батлан хамгаалах: Физик болон кибер аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үндэсний аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх.

6. Байгаль орчны сөрөн тэсвэрлэх чадавх: Экосистемийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах.

Өнөөгийн байдлаар дэлхийд “Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги болон тогтолцоо” гэж нэрлэн мөрдөж байгаа Япон, Доминикан зэрэг 8 улс орнууд байна¹⁵. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон 2015-2030 он хүртэл Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн тогтолцоо баримт бичигт нийцүүлэн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегийг баталж, хэрэгжүүлээд байгаа нийт 129 улс, түүнчлэн 2023 оны 6-р сарын байдлаар 198 улсаас 128 (ойролцоогоор 65%) нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг арилгахын тулд үндэсний дасан зохицох төлөвлөгөөгөө боловсруулсан байна¹⁶. Байгалийн гамшиг, аюулгүй байдлын заналхийлэл, кибер халдлага, эрүүл мэндийн хямрал зэрэг янз

¹⁴ Boin, A., Comfort, L. K., & Demchak, C. C. (2010). Resilience in response to crises: The national perspective. *Journal of Homeland Security and Emergency Management*, 7(1), 1–14. [https://doi.org/\[insert-actual-DOI-if-available\]](https://doi.org/[insert-actual-DOI-if-available])

¹⁵ Cabinet Secretariat, Government of Japan. (2014). *Fundamental Plan for National Resilience*. Retrieved from <https://www.cas.go.jp>

Government of Malawi. (2018). *National Resilience Strategy 2018-2030: Breaking the cycle of food insecurity in Malawi*. Retrieved from <https://leap.unep.org>

Government of Dominica. (2018). *National Resilience Development Strategy Dominica 2030*. Retrieved from <https://leap.unep.org>

Government of Lesotho. (2019). *Lesotho National Strategic Resilience Framework 2019-2030*. Retrieved from <https://leap.unep.org>

Government of Lao PDR. (n.d.). *National Resilience Framework*. Retrieved from <https://leap.unep.org>

European Journal of Futures Research. (2022). *National Resilience Frameworks in Sweden, Israel, and Australia*. Retrieved from <https://eujournalfuturesresearch.springeropen.com>

¹⁶ United Nations Conference on Trade and Development (UNCTAD). (2023). *National disaster risk reduction strategies: Progress in line with the Sendai Framework for Disaster Risk Reduction 2015–2030*. Retrieved from <https://sdgpulse.unctad.org>

McKinsey & Company. (2023). *Paving the way to resilience: Strengthening public sector adaptation planning and execution*. Retrieved from <https://www.mckinsey.com>

бүрийн аюул заналхийлэлд хариу арга хэмжээ авах, түүнийг даван туулах чадавхыг сайжруулахын тулд олон улс орон үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги эсвэл тогтолцоог бий болгосон байна. Тухайлбал:

Америкийн Нэгдсэн Улс

- Үндэсний аюулгүй байдлын стратеги (National Security Strategy-NSS): Үндэсний аюулгүй байдал, улс орны чухал дэд бүтцүүд, кибер аюулгүй байдлын хүрээнд сөрөн тэсвэрлэх чадавхыг багтаасан.

- Холбооны онцгой байдлын ерөнхий газар (Federal Emergency Management Agency-FEMA): Сөрөн тэсвэрлэх чадавхыг удирдан чиглүүлэхийн тулд гамшгийн нөлөөг багасгах үндэсний тогтолцоо болон хариу арга хэмжээ авах үндэсний тогтолцоо бий болгосон.

Их Британи

- Гадаад бодлого, хөгжил, батлан хамгаалах, аюулгүй байдлын нэгдсэн бодлого (2021): Уур амьсгалын өөрчлөлт, эрүүл мэндийн эрсдэл зэрэг аюул заналхийллийг даван туулахад анхаардаг.

- Үндэсний сөрөн тэсвэрлэх тогтолцоо (2022): Нийгэм болон дэд бүтцийн чадавхыг бэхжүүлэх замаар онцгой байдлын үед Их Британийн бэлэн байдлыг бэхжүүлэх зорилготой.

Европын Холбоо

- Европын холбооны сөрөн, тэсвэрлэх стратеги: Геополитик, байгалийн гамшиг, уур амьсгалын эрсдэлээс сөрөн тэсвэрлэх чадавхад чиглэдэг.

- Европын холбоо нь иргэний хамгаалалтын тогтолцоогоороо сөрөн тэсвэрлэх чадавхыг дэмждэг.

Япон

- Байнгын хар салхи, газар хөдлөлтүүдийн улмаас тохиолдох гамшгаас сөрөн тэсвэрлэх чадавхад ихээхэн анхаарал хандуулдаг.

- Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын суурь акт (2013) нь гамшгаас урьдчилан сэргийлэх, түргэн сэргээх чадавхыг чухалчилдаг.

Манай улсын хоёр хөрш улс болох Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улсууд аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн сайн сайхан байдлын олон талт асуудлыг авч үзэж, үндэснийхээ сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх иж бүрэн стратеги, тогтолцоог боловсруулсан байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хятадын үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хангах үзэл баримтлал нь 2014 онд Ши Жиньпин даргын дэвшүүлсэн "Үндэсний цогц аюулгүй байдал" гэсэн үзэл баримтлалд тусгагдсан байдаг. Энэхүү тогтолцоо нь улс төр, эдийн засаг, цэрэг арми, соёл, байгаль орчны аюулгүй байдал зэрэг аюулгүй байдлын өргөн хүрээг хамардаг. Үндэсний бүрэн эрх, хөгжлийн эрх ашгийг хамгаалсан цогц тогтолцоог бий болгох зорилготой¹⁷. Үүнтэй уялдуулан Хятад улсын "Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний стратеги 2035"-д цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг сайжруулах, хяналт, уян хатан дэд бүтэц, тогтвортой хөгжлийн арга

¹⁷ Wikipedia contributors. (n.d.). Holistic national security. Wikipedia. Retrieved February 6, 2025, from https://en.wikipedia.org/wiki/Holistic_national_security

бариллаар дамжуулан бэхжүүлэх төлөвлөгөөг тусгасан байна. Мөн "Хятадад үйлдвэрлэв-2025" санаачилга нь инновацыг сайжруулж, гадаад технологиос хараат байдлыг бууруулж, улмаар эдийн засгийн сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх замаар Хятадыг тэргүүлэх үйлдвэрлэлийн гүрэн болгоход чиглэсэн байна.

Оросын Холбооны Улс

ОХУ-ын үндэсний сөрөн тэсвэрлэх тогтолцоог 2021 онд хамгийн сүүлд шинэчлэн “Үндэсний аюулгүй байдлын стратеги”-даа тусгасан байдаг. Энэхүү стратегид үндэсний батлан хамгаалах, төрийн болон олон нийтийн аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдал, соёлын үнэт зүйлсийг хадгалах зэрэг үндсэн чиглэлүүдийг тодорхойлсон. Энэ нь улс орноо төрөл бүрийн аюул заналхийллээс сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэхийн тулд дотоод аюулгүй байдал, улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой болохыг онцолдог байна¹⁸. Мөн ОХУ-ын Онцгой байдлын ерөнхий газрын (Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг бууруулах яам) удирдлагад Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний тогтолцоог байгуулсан. Энэхүү тогтолцоо нь байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшгийн үр дагаврыг арилгах чадавхыг сайжруулахад чиглэсэн төрийн байгууллагууд болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэгтгэдэг байна.

Хоёр улс дэлхийн хэмжээнд шинээр гарч ирж буй сорилтуудыг шийдвэрлэхийн тулд сөрөн тэсвэрлэх стратегиа үргэлжлүүлэн хөгжүүлсээр байна.

Монгол Улсын хувьд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхад чиглэсэн нэлээдгүй хууль, эрх зүйн барим бичгүүд байна¹⁹. Одоогийн байдлаар МУ-д “Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги” боловсрогдон гараагүй байна. 2024 оны Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалт “Монгол Улсын оршин тогтнохуйн аюулгүй байдалд тулгамдаж буй эрсдэл, сорилт ба удирдагчийн сэтгэлгээний өөрчлөлт” сэдвийн дор өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулагдах үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ухнаагийн Хүрэлсүх цугларалтад оролцон, удирдах бүрэлдэхүүнд үүрэг, чиглэл өгөхдөө болзошгүй аюул, заналхийлэл, гамшгаас урьдчилан сэргийлэх, түүнийг хохирол багатай даван туулж, төр, нийгмийн үйл ажиллагааг сэргээн босгох чадавх, бэлэн байдлыг

¹⁸ TASAM. (2021). The Russian Federation's National Security Strategy of 2021: The increasing importance of internal security. Retrieved February 6, 2025, from <https://tasam.org/en/Icerik/70118>

¹⁹ Монгол Улсын үндсэн хууль

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Хот байгуулалтын тухай Монгол Улсын хууль

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Монгол Улсын хууль

Улс төрийн намын тухай Монгол Улсын хууль

Үндэсний аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль

Галын аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль

Кибер аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай Монгол Улсын хууль

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль

Монгол улсын батлан хамгаалах тухай Монгол Улсын хууль

Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс

Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хууль

хангах зорилгоор “Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги”-ийг батлан хамгаалах болон гамшигтай тэмцэх тогтолцоонд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх цаг болсныг тэмдэглэсэн юм²⁰. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Батлан хамгаалахын сэргэлт” салбарын удирдах бүрэлдэхүүний зөвлөгөөнд оролцож, үг хэлэхдээ “Сөрөн тэсвэрлэх чадавх-Батлан хамгаалах тогтолцоо”-г бэхжүүлэх зорилт Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссаныг онцолсон юм²¹. Батлан хамгаалахын сайдын 2025 оны эхний өргөтгөсөн шуурхай хуралдаанаар /2025.01.06/ Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт нээж, хэлсэн үгэндээ, Бид энэ 2025 оныг “Эх оронч Монгол –Их сэргэлтийн жил” болгон зарлаж байна гэсэн юм²². Мөн энэ ажлын хүрээнд Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт “Эх оронч Монгол-Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх” сэдэвт батлан хамгаалах салбар, нийт бие бүрэлдэхүүнийхээ дунд илтгэлийн уралдаан зарласан²³. Эндээс үзэхэд “Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги” боловсруулах ажилд МУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Батлан хамгаалахын сайд нар өндөр ач холбогдол өгч, анхаарал хандуулан ажиллаж байгаа нь харагдаж байна.

III. ЭХ ОРОНЧ МОНГОЛ

Эх оронч үзэл бол эх орноо хайрлах, үнэнч байх мэдрэмж юм²⁴. Энэ нь тухайн үндэстний соёл, түүх, үнэт зүйл, ололт амжилтаараа бахархах мэдрэмжийг агуулдаг. Эх оронч хүмүүс үндэсний эрх ашгийг дэмжих, иргэний үүргээ биелүүлэх, төрөө дээдлэх, нийгмийн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулах замаар эх оронч үзлээ илэрхийлж болно. Гэсэн хэдий ч эх оронч үзэл нь иргэний бүтээлч оролцооноос эхлээд үндэсний баяраа тэмдэглэх, төрийн дууллаа эгшиглүүлэх гэх мэт үндэсний бахархлыг илүү харуулах зэрэг янз бүрийн хэлбэртэй байж болно.

Эх оронч үзэл нь нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх, хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэний хариуцлагыг хөхүүлэн дэмжих замаар үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг²⁵. Эх оронч үзэл нь үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхад дараах байдлаар хувь нэмэр оруулж болно.

Яаралтай тусламж болон сайн дурын ажил: Байгалийн гамшиг эсвэл үндэсний хэмжээний хямралын үед эх оронч иргэд ихэвчлэн сайн дурын тусламж үзүүлэх, нөөц хөрөнгөө хандивлах, орон нутагтаа туслах хүсэл эрмэлзэлтэй байдаг нь улс орны хурдан сэргэх чадварыг нэмэгдүүлдэг.

Үндэсний батлан хамгаалах болон аюулгүй байдал: Эх оронч үзэл нь хувь хүмүүсийг цэрэг, хууль сахиулах, тагнуулын байгууллагад алба хаах эрмэлзлийг

²⁰ <https://president.mn/28409/>

²¹ <https://news.mn/t/2752900/>

²² <http://mod.gov.mn/?p=10857>

²³ <https://www.facebook.com/byambatsogt.s>

²⁴ Merriam-Webster. (n.d.). Patriotism. In Merriam-Webster.com dictionary. Retrieved February 9, 2025, from <https://www.merriam-webster.com/dictionary/patriotism>

²⁵ Smith, J. (2022, July 15). The link between patriotism and national resilience. National Review. <https://www.nationalreview.com/article/link-patriotism-resilience>

төрүүлдэг бөгөөд энэ нь улс орны өөрийгөө гаднын аюулаас батлан хамгаалах чадавхыг бэхжүүлдэг.

Эдийн засгийн тогтвортой байдал: Үндэсний бахархал нь хувь хүмүүст дотоодын бизнес, үйлдвэрүүдийг дэмжих, гадаадын бараа, үйлчилгээнээс хараат байдлыг бууруулж, бие даасан эдийн засгийг дэмжихэд түлхэц болно.

Хямралыг сэргээх: Эх оронч зохиол, өгүүллэгүүд нь террорист халдлага, тахал өвчин, улс төрийн үймээн самуун зэрэг үйл явдлын дараа хүмүүсийг нэгтгэж, өмнөхөөсөө илүү хүчтэй сэргээн босгох хамтын шийдлийг бий болгоход тусалдаг.

Улс төрийн тогтвортой байдал болон иргэний оролцоо: Эх оронч үзэлтэй иргэд сонгуульд идэвхтэй оролцох, саналаа өгөх, улс төрийн бүтээлч яриа хэлэлцээ өрнүүлэх, үндэсний хөгжил, аюулгүй байдлыг дэмжсэн бодлогыг сурталчлах магадлал өндөр байдаг.

Үндэсний соёл болон өвөрмөц онцлогийг уламжлуулах: Эх оронч үзэл нь ихэвчлэн соёлын өв, уламжлалыг эрхэмлэдэг бөгөөд энэ нь итгэл үнэмшлээ алдах, аливаа саад бэрхшээлийн үед хүч чадал, залгамж холбооны эх үүсвэр болдог.

Эх оронч хүн гэдэг нь эх орондоо хайртай, үнэнч, үнэнч гэдгээ харуулсан хүнийг хэлнэ²⁶. Тэд эх оронч үзлээ ихэвчлэн үндэстнийхээ сайн сайхан байдал, ашиг сонирхлыг дэмжсэн үйлдэл, итгэл үнэмшил, мэдрэмжээрээ илэрхийлдэг. Эх оронч хүн эх орныхоо соёл, түүх, үнэт зүйл, ололт амжилтаараа бахархдаг бөгөөд тэд ихэвчлэн нийгмээ сайжруулахын төлөө ажилладаг. Эх орончид иргэний үүргээ идэвхтэй гүйцэтгэж, үндэсний батлан хамгаалах тогтолцоог дэмжиж, үндэсний бэлгэ тэмдгийг дээдэлж, нийгэм, улс төрийн тогтвортой байдлыг дэмждэг байна. Тэртээ 100 гаруй жилийн өмнө Ардын Хатанбаатар Магсаржав “Би Монгол хүн гэж хэлэхийн тулд Монголын төлөө цохилдог зүрхтэй байх ёстой” гэж хэлсэн нь одоо ч үнэ цэнээ алдаагүй бөгөөд орчин үеийн гадаад, дотоодын нэр томъёоны тайлбар толиуд, судалгааны ажлуудад тодорхойлсонтой үндсэндээ агуулгын хувьд адил байна. Эх оронч хүн гэдэг нь эх орондоо хайртай, өв уламжлалаа хүндэтгэдэг, үндэсний батлан хамгаалах, аюулгүй байдлын бодлогыг дэмждэг, сурталчилдаг, улс орныхоо төлөө ажиллаж, амьдардаг түүнийгээ батлан харуулсан иргэнийг хэлж болно.

Үндэсний батлан хамгаалахын их сургууль маань улс, эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ жанжин Д.Сүхбаатарын санаачилгаар байгуулагдсан цагаасаа хойш нэр төртэй биелүүлсээр ирсэн. Тус сургууль үнэт зүйлсдээ “Үндэсний язгуур эрх ашиг, Уламжлал, Шинэчлэл, Цэрэг, эх оронч үзэл, Эрдэм мэдлэг, Нэр төр, Ёс зүй, Нийгмийн хариуцлага хэмээн тодорхойлсон”²⁷ нь Эх оронч Монгол хүнийг бэлтгэх, сурган хүмүүжүүлэх ажилд үйл ажиллагаагаа чиглүүлж байгаа нь харагдаж байна. 2025 оныг ҮБХИС "Чанартай сургалт-Чадварлаг оюутан" жил болгон зарласан. Эх оронч монгол хүнийг бэлтгэх их үйлсдээ шамдан орж байгааг харуулж байна.

²⁶ Merriam-Webster. (n.d.). Patriot. In Merriam-Webster.com dictionary. Retrieved February 9, 2025, from <https://www.merriam-webster.com/dictionary/patriot>

²⁷ <http://mndu.gov.mn/bhis1/mn/%d0%bd%d2%af%d2%af%d1%80/>

IV. ДҮГНЭЛТ

Өнөөдөр дэлхийн улс орнууд өөр өөрсдийн онцлогт нийцүүлэн Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги болон тогтолцоог бүрдүүлэн мөрдөж байна. Салбар бүр өөрийн сөрөн тэсвэрлэх бодлогыг боловсруулж, МУ-н Үндэсний сөрөн тэсвэрлэх стратегийг боловсруулан Улсын Их Хурлаар хэлэлцэн баталж бүх нийтээрээ мөрдөх ажлыг эхлүүлэх нь өндөр ач холбогдолтой нь судалгаанаас харагдаж байна. Манай улсын хувьд өөрийн онцлогийг харгалзан геополитикийн нөхцөл, газарзүйн байрлал, хууль, эрх зүйн орчин, эдийн засгийн нөхцөл, байдал, өв уламжлал, соёл, түүхэн сургамжийг тусган Үндэсний сөрөн тэсвэрлэх стратегийг боловсруулах нь зүйтэй юм.

Салбар бүрд энэ чиглэлийн судалгааг идэвхжүүлэх, судлаачдын судалгааны ажлыг чиглүүлэх судалгааны ажлыг санхүүжүүлж, судалгааны ажлын үр дүнг хэлэлцэх, дотоод гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлэх шаардлагатай.

Цэрэг батлан хамгаалах, аюулгүй байдлын түвшин өндөр хөгжсөн гадаадын улс орнуудын Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги болон тогтолцоонд нарийн шинжилгээ хийж, өөрийн орны стратегид тусгах. МУ-тай геополитик болон газарзүйн хувьд ижил төстэй улсуудын Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги болон тогтолцоонд судалгаа хийж, өөрийн оронд хэрэглэж болох туршлагыг судлах нь ач холбогдолтой юм. Мөн хөрш хоёр улсын Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги болон тогтолцоонд нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай байна.

Эх оронч үзэл нь нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх, хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэний хариуцлагыг хөхүүлэн дэмжих замаар үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг нь судалгаанаас харагдаж байна. Эх оронч иргэн Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх, нэмэгдүүлэх үндсэн субъект болж байна. Эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх, эх оронч монгол хүн үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхийг нэмэгдүүлэх тулгуур хүчин болж байна.

Эх оронч Монгол хүнийг бэлтгэхэд дотоодын бүх шатны боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэх. Хичээлийн хөтөлбөрт Эх оронч үзлийн талаар хичээл тусгах, хичээлийн агуулгыг тогтмол шинэчилж байх шаардлагатай байна.

Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажилд чиглүүлэх. Хугацаат цэргийн албан хаагчид болон байнгын бие бүрэлдэхүүний сургалт, дадлагын хичээлд эх оронч үзлийн талаар хичээлийг тусгах, агуулгыг шинэчлэх. Мөн Үндэсний батлан хамгаалахын их сургуулийг Үндэсний хэмжээний “Цэрэг-Эх оронч” үзлийн төв болгон хөгжүүлэх бүрэн боломжтой юм.

ЭШ ТАТСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

- [1] Boin, A., Comfort, L. K., & Demchak, C. C. (2010). Resilience in response to crises: The national perspective. *Journal of Homeland Security and Emergency Management*, 7(1), 1–14. <https://doi.org/insert-actual-DOI-if-available>

- [2] Cabinet Secretariat, Government of Japan. (2014). Fundamental Plan for National Resilience. Retrieved from <https://www.cas.go.jp>
- [3] Government of Malawi. (2018). National Resilience Strategy 2018-2030: Breaking the cycle of food insecurity in Malawi. Retrieved from <https://leap.unep.org>
- [4] Government of Dominica. (2018). National Resilience Development Strategy Dominica 2030. Retrieved from <https://leap.unep.org>
- [5] Government of Lesotho. (2019). Lesotho National Strategic Resilience Framework 2019-2030. Retrieved from <https://leap.unep.org>
- [6] Government of Lao PDR. (n.d.). National Resilience Framework. Retrieved from <https://leap.unep.org>
- [7] European Journal of Futures Research. (2022). *National Resilience Frameworks in Sweden, Israel, and Australia*. Retrieved from <https://eujournaloffuturesresearch.springeropen.com>
- [8] United Nations Conference on Trade and Development (UNCTAD). (2023). National Disaster Risk Reduction Strategies: Progress in Line with the Sendai Framework for Disaster Risk Reduction 2015–2030. Retrieved from <https://sdgpulse.unctad.org>
- [9] McKinsey & Company. (2023). Paving the way to resilience: Strengthening public sector adaptation planning and execution. Retrieved from <https://www.mckinsey.com>
- [10] Wikipedia contributors. (n.d.). Holistic national security. Wikipedia. Retrieved February 6, 2025, from https://en.wikipedia.org/wiki/Holistic_national_security
- [11] TASAM. (2021). The Russian Federation's National Security Strategy of 2021: The increasing importance of internal security. Retrieved February 6, 2025, from <https://tasam.org/en/Icerik/70118>
- [12] Монгол Улсын үндсэн хууль
- [13] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- [14] "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- [15] Хот байгуулалтын тухай Монгол Улсын хууль
- [16] Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Монгол Улсын хууль
- [17] Улс төрийн намын тухай Монгол Улсын хууль
- [18] Үндэсний аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль
- [19] Галын аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль
- [20] Кибер аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль
- [21] Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай Монгол Улсын хууль.
- [22] Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль
- [23] Монгол улсын батлан хамгаалах тухай Монгол Улсын хууль
- [24] Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс
- [25] Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хууль
- [26] <https://president.mn/28409/>
- [27] <https://news.mn/r/2752900/>
- [28] <http://mod.gov.mn/?p=10857>
- [29] <https://www.facebook.com/byambatsogt.s>
- [30] Merriam-Webster. (n.d.). Patriotism. In Merriam-Webster.com dictionary. Retrieved February 9, 2025, from <https://www.merriam-webster.com/dictionary/patriotism>
- [31] Smith, J. (2022, July 15). The link between patriotism and national resilience. National Review. <https://www.nationalreview.com/article/link-patriotism-resilience>
- [32] Merriam-Webster. (n.d.). Patriot. In Merriam-Webster.com dictionary. Retrieved February 9, 2025, from <https://www.merriam-webster.com/dictionary/patriot>
- [33] <http://mndu.gov.mn/bhis1/mn/%d0%bd%d2%af%d2%af%d1%80/>